

# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

## ИЛТГЭХ ХУУДАС

2023 оны 08 дугаар сарын 10

Номгон

Гурванбулаг сумын Засаг даргын тамгын газрын  
2023 оны эхний хагас жилийн үйл  
ажиллагаанд хяналт-шинжилгээ,  
үнэлгээ хийсэн тухай

### **Нэг.Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, аргачлал, хамрах хүрээ:**

Нутгийн захиргааны байгууллагуудын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт, зөвлөмж өгөх, бодлого, үйл ажиллагааны үр нөлөө, сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх, зорилгоор танай байгууллагын 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг үнэлэхдээ Аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”, байгууллагын нээлттэй, ил тод байдлыг үнэлэхдээ Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг тус тус баримтлав.

#### **Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээнд:**

- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт;
- Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлт;
- Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт;
- Дэд хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт;

#### **Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээнд:**

- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт;
- Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт;
- Зөвлөмжийн хэрэгжилт;

#### **Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн хэрэгжилтийн үнэлгээнд:**

- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан;
- Аймгийн Засаг даргатай сумын Засаг даргын байгуулсан гэрээний хэрэгжилт

- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлт;
- Орон нутгийн хөгжлийн сангийн үнэлгээ;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн үнэлгээ;
- Байгууллагын ил тод байдлын үнэлгээ;
- Шилэн дансны үнэлгээ;

Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээнд:

- Ногоон байгууламж (Мод тарих);
- Цахим шилжилт;
- Хог хаягдлын менежментийн үнэлгээ зэрэг 17 тайланг хянаж, үнэлгээг тооцсон.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлт, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, дэд хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт, сумын Засаг дарга аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний үүргийн биелэлт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлт, байгууллагын ил тод байдлын үнэлгээ зэрэг 11 тайланг Баянхонгор аймгийн Хяналт- шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангаар хүлээн авч үнэлсэн.

Зөвлөмжийн хэрэгжилт, Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний Ногоон байгууламж нэмэгдүүлэх арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээг тухайн байгууллагаас Цаасаар ирүүлсэн тайланг үндэслэн, Цахим шилжилт арга хэмжээний үнэлгээг Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн үнэлгээгээр, Архив, албан хэрэг хөтлөлтийн үнэлгээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Төрийн архивын тасгийн үнэлгээгээр дүгнэлээ.

#### **Хоёр.Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн:**

Гурванбулаг Засаг даргын Тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээг тайлан тус бүрээр танилцуулья.

#### **2.1- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ:**

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 33 арга хэмжээг хяналтад авч хэрэгжүүлсэн тайланг хянан үзэж, 72.42% -иар үнэлсэн.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг гаргахдаа шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд нийцүүлэн, тайланд тавих шаардлагыг ханган тайлагнах шаардлагатай байна.

Хүснэгт 1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Байгууллагын нэр	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)				Дундаж үнэлгээ (0/10)
	Эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй ажлыг	Тодорхой үр дүнд хүрсэн	Үр дүнтэй	Эрчимжүүлэх шаардлагатай	
Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар	33	17			72.42%

аймгийн хяналт шинжилгээ, үнэлгээний цахим сангаас харах.

## 2.2- Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ:

Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 13 арга хэмжээг хэрэгжүүлж, тайлагнасныг хянан үзэж, 51.54%-иар үнэлсэн.

Хүснэгт 2.Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Байгууллагын нэр	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)				Дундаж үнэлгээ (0/10)
	Эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй ажлыг	Тодорхой үр дүнд хүрсэн	Үр дүнтэй	Эрчимжүүлэх шаардлагатай	
Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар	13				51.54

Эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй ажлыг аймгийн хяналт шинжилгээ, үнэлгээний цахим сангаас харах.

## 2.3.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 83 зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж 56.63%-иар гэж дүгнэлээ.

Хүснэгт 3. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Д/д	Хяналтад авсан	Үүний дотор /заалтын тоо/							Хэрэгжилтийн хувь
Сумын нэр	Арга хэмжээний	100%	90%	70%	50%	30%	0%	тоо	
Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)									
Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2020-2024/									
1 Гурванбулагсумын Засаг даргын Тамгын газар	83	8	27	20	13	8			56.63%

Эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй ажлыг аймгийн хяналт шинжилгээ, үнэлгээний цахим сангаас харах.

## 2.4. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ:

Аймгийн дэд хөтөлбөрүүдээс 6 дэд хөтөлбөрийн 33 арга хэмжээг хэрэгжүүлэн, тайлагнасан байна. Сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн дэд хөтөлбөрийн тайланг хянан үзэж, 46.1%-иар үнэлэв.

Хүснэгт 4. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Байгууллагын нэр	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)						Дундаж үнэлгээ (%)
	Орлог, үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Хэрэгжүүлэх шаардлагатай	Хэрэгжүүлэх шаардлагатай	
Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар	6	33	4	6	19	4	46.1

Эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй ажлыг аймгийн хяналт шинжилгээ, үнэлгээний цахим сангаас харах.

## 2.5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ:

Монгол Улсын хууль, Улсын Их хурлын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар үүрэгжүүлэн өгсөн нийт 17 тогтоолын 27 заалтын хэрэгжилтийг хянан үзэж, 51.11% -иар үнэлэв.

Хүснэгт 6. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн

Байгууллагын нэр	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)							Дундаж үнэлгээ (%)
	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжилт хангалгүй	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжээгүй	
Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар	17	27	3	12	8	4		51.11

Эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй ажлыг аймгийн хяналт шинжилгээ, үнэлгээний цахим сангаас харах.

## 2.6. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ:

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 9 тогтоол, шийдвэрийн 9 заалтын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж 65.56%-иар дүгнэв.

Хүснэгт 6. Аймгийн ИТХ-ын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Байгууллагын нэр	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)						Дундаж үнэлгээ (%)
	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Хэрэгжсэн	Хэрэгжих	Хэрэгжилт хангалгүй	Хэрэгжээгүй	
Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар	9	9	8	1	3	-	65.56

## 2.7. Аймгийн Засаг даргын захирамж, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ:

Аймгийн Засаг даргын 25 захирамж, албан даалгаврын 78 заалтыг хэрэгжүүлж, тайлагнасныг хянан үзэж, 61,47%-иар үнэллээ.

Хүснэгт 7.АЙМГИЙН Засаг даргын захирамж, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Байгууллагын нэр	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)						« Дунда го Т Ж го 8 үнэлгэ э(%)
	Х	В	х х ь *	Р	х тм	т * I o	
Гурванбулаг сумын Засаг 25 даргын Тамгын газар	78	19	31	18	7	3	61.47%

Эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй ажлыг аймгийн хяналт шинжилгээ, үнэлгээний цахим сангаас харах.

## 2.8. Зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээ:

Сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны жилийн эцсийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт- шинжилгээ, үнэлгээний мөрөөр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 0%-иар үнэлэв.

Хүснэгт 8.Зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Байгууллагын нэр	Хэрэгжилтийн хувь
Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар	0%

## 2.9. Сумын Засаг дарга аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт:

Сумын Засаг дарга аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 145 заалтын хэрэгжилтийг 80,4% -иар дүгнэлээ.

Хүснэгт 9. Сумын Засаг дарга аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үнэлгээний дүн:

Байгууллагын нэр	Гэрээний заалтын тоо	Дундаж үнэлгээ
Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар	145	80,4%

Эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй ажлыг аймгийн хяналт шинжилгээ, үнэлгээний цахим сангаас харах.

## 2.10. Байгууллагын гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээ:

Сумын Засаг даргын Тамгын газар 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг цахим системээр тайлагнасан тайланг хянан үзэж, 80%-иар үнэлсэн Хүснэгт Ю.Байгууллагын гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээний дүн:

		Дундаж						
д/д Байгууллагын нэр	З	Арга	100%	90%	70%	50%	30%	0%
	хэмжээ							

1 Гурванбулаг


8	70	40	16	12	2	-	-	80%
даргын								
Тамгын газар								

Эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй ажлыг аймгийн хяналт шинжилгээ, үнэлгээний цахим сангаас харах.

### 2.11. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ:

Тус газрын төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн 2 зорилт, 7 арга хэмжээний 2023 оны тайланг хянан үзэж, 65,71%-иар үнэлэв.


Хүснэгт И.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:



### 2.12. Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээ:

Байгууллагын ил тод байдлыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн 5 төрлийн 46 мэдээлэл тус бүрээр хянан үзэж, 82.19%-иар үнэлэв.

Хүснэгт 12.Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээний дүн:




Хэрэгжих шатандаа ажлыг аймгийн хяналт шинжилгээ, сангаас харах.

### 2.13. Архив, албан хэрэг хөтлөлтийн үнэлгээ:

Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны үнэлгээг аймгийн Засаг даргын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн үнэлгээгээр 100% гэж дүгнэлээ.

Хүснэгт 13.Байгууллагын архивын үнэлгээ:



### 2.14. Орон нутгийн хөгжлийн сангийн үнэлгээ

Орон нутгийн хөгжлийн сангийн үнэлгээг.

- 2024 оны төлөвлөлтийг багийн ИНХ-аар хугацаанд нь хэлэлцэж баталсан эсэх;
- Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх иргэдийн саналыг эрэмбэлэх ажлын хэсэг

байгуулагдсан эсэх;

- Төсвийг хуулийн хугацаанд, маягтын дагуу баталсан эсэх;
- ОНХС-ийн үйл ажиллагааны үр дүнг сумын албан ёсны цахим хуудсаар мэдээлсэн

эсэх;

- 2022 оны хөрөнгийг өмчид бүртгэсэн эсэх үзүүлэлтээр хянан шалгаж, Гурванбулаг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн үнэлгээг 100% -иар үнэллээ.

### **2.15.Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ:**

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээнд тусгагдсан ногоон байгууламжийн тайланг дутуу ирүүлснээс үнэлэх боломжгүй тул 0% гэж дүгнэлээ.

#### **Ногоон байгууламж**

Тарьсан моднытоо №	Сумын нэр	Мод, сөөгний тоо	Суулгац	Нийт	Хувь	Ургалтын хувь	Хувь	Нийт хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар	50		50	100			

Хог хаягдлын шалгуур үзүүлэлтийн тайланг сумын дүнгээр гаргаж ирүүлээгүй.

Цахим шилжилт арга хэмжээний тайланг Баянхонгор аймгийн Төрийн цахим үйлчилгээний хэлтэс Цахим үйлчилгээ, Цахим хуудас ашиглалт, ЕКР систем, албан бичиг программ СОСХ системд холбогдсон эсэх үзүүлэлтээр үнэлснийг ерөнхий үнэлгээнд орууллаа. Хүснэгт 14.Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой арга хэмжээний цахим шилжилт арга хэмжээний хэрэгжилт:

Д/д	Байгууллагын нэр	Цахим үйлчилгээ	Цахим хуудас, ил тод	ЕКР систем Хүний нөөц	Албан бичиг, Нийлбэр ДҮН
	Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар	63.02%	90.61%	78.80%	77.48%

## Хүснэгт 16. Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2023 эхний хагас жилийн

үнэлгээний дүн:

Үзүүлэлт		Үнэлгээний ДҮН
1	2	1
Бодлогын баримт бичиг болон Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ	1.АЙМГИЙН Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт (хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон хяналт- шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хамт)	72.42
	2.АЙМГИЙН хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт	51.54
	3.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	56.63
	4.Дэд хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	46.10
	6.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт	65.56
	6.Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Засаг даргын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт	61.47
	7.Зөвлөмжийн хэрэгжилт	0.00
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	80.00
	2.Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт	80.40
	3.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлт	65.71
	4.Орон нутгийн хөгжлийн сангийн үнэлгээ	100.00
	6.Архив, албан хэрэг хөтлөлтийн үнэлгээ	100.00
	6.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	82.19
	7.Шилэн данс	90.60
Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ	1 .Ногоон байгууламж (Мод тарих)	0.00
	2.Цахим шилжилт	77.48
	3.Хог хаягдлын менежмент	0.00
Дундаж үнэлгээ		59.16
Ирүүлээгүй тайлан		3
Хоцроосон тайлан		1
Ерөнхий үнэлгээ:		42.16

**Гүрав.Дүгнэлт:**

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр 42.16% буюу “хангалтгүй” үнэлэгдсэн боловч, өнгөрсөн оны мөн үеэс 9.9% -иар өссөн үзүүлэлттэй байна.

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь зөвлөмжийн хэрэгжилт, ногоон байгууламж, хаягдлын менежментийн үнэлгээ гэсэн 3 тайланг ирүүлээгүй, 1 тайлан хоцроосноос нийтдүнгээс 17 оноо хасуулсан байна.

Сумын Засаг даргын Тамгын газар нь тайлангийн хугацааг хоцроох, тайлан ирүүлэхгүй байх зэрэг зөрчил гаргахгүй, төрийн албан хаагчдын үүрэг хариуцлага, ажилдаа хандах хандлагыг нэмэгдүүлэн ажиллах хэрэгтэй.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн зөвлөмжийг хяналтад авч, хэрэгжүүлж ажиллаагүйгээс алдаа, дутагдал дахин давтагдсаар байгаад анхаарах.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт эрчимжүүлэх шаардлагатай 7, жилийн хөгжлийн төлөвлөгөөнд эрчимжүүлэх шаардлагатай 7, үр дүнгүй 1, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт эрчимжүүлэх шаардлагатай 33, үр дүнгүй 8 заалт, дэд хөтөлбөрүүдийн эрчимжүүлэх шаардлагатай 19, үр дүнгүй 4 заалт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 30% -тай 8, 0% -тай 4, аймгийн Засаг даргын захирамжийн 30% -тай 18, 0% -тай 7 заалт тус бүрийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийж, нэмэлт төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг бүрэн хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, сахилга хариуцлагыг дээшлүүлж ажиллах нь зүйтэй.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуульд заасан мэдээллийг ил тод, нээлттэй болгож, иргэдийг үнэн зөв, бүрэн, ойлгомжтой мэдээллээр хангах, мэдээллийн үйлчилгээг шуурхай, хялбар болгоход анхаарч, хуулийг хэрэгжүүлж ажиллах, хуулийг хэрхэн хэрэгжүүлсэн үр дүнгээ зөв тайлагнаж сурах шаардлагатай.

ХЯНАСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИ  
ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН БИЧСЭН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,

ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Л.МАНДАЛ

.БАТБАЯР



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЗАСАГДАРГЫН ТАМГЫН ГАЗАР  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС  
ЗӨВЛӨМЖ**

оны сарын С/өдөр

Дугаар /с/

Номгон

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг  
эрчимжүүлэх тухай

Сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн цаашид дор дурдсан асуудалд анхаарал хандуулж, удирдлага, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газарт зөвлөж байна.

**1 .Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах талаар:**

1.1. АЙМГИЙН Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөр, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээгээр үр дүнгүй, эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн нийт 79 арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, захирамжийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй 37 заалт тус бүрийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийж, нэмэлт төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг бүрэн хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

1.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээг үр дүнд чиглүүлж, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинг тодорхой, оновчтой, үр дүнг илэрхийлэхүйц, хэмжих боломжтой байдлаар албан ёсны статистик үзүүлэлтэд суурилж, аймгийн бодлоготой уялдуулан тодорхойлох, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар баталсан” Байгууллагын гүйцэтгэлийн тайлангийн загвар”-ыг баримтлан боловсруулж, тайлагнах;

1.3. Бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, түүний эх үүсвэрийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитой төлөвлөх, төсөвт тусгуулах;

1.4. Бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг оны эхнээс жигд ханган хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, хэрэгжилт удаашралтай, хангалтгүй арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч, тухайн жилийн хэрэгжилтийг бүрэн хангах;

1.5. Төрийн албан хаагчдыг сургалтад хамруулах, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулах чиглэлээр төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах;.

## **2 .Хэрэгжилтийн тайлагналыг сайжруулах талаар:**

2.1. АЙМГИЙН Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг хугацаанд нь бүрэн тайлагнаж хэвших;

2.2. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг богино хугацааны үр дүн, дунд хугацааны үр нөлөөг илэрхийлэх тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн, үнэн зөв тайлагнаж байх;

2.3. Санхүүжилтийн гүйцэтгэл, эх үүсвэрийг арга хэмжээ бүрээр бүрэн тайлагнаж байх;

2.4. АЙМГИЙН хяналт-шинжилгээ, үнэлгээний [БауапкНопдоидоуеттепбдоу.тп](http://BayanKhopdoidogettepbay.tl) мэдээллийн цахим санд тухайн арга хэмжээний хэрэгжилтийг баталгаажуулах нотлох баримтыг хавсаргаж байх;

2.5. Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг тайлагнахдаа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг хэрхэн хэрэгжүүлсэн үр дүнгээ зөв тайлагнах;

## **3 .Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах талаар:**

3.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.12-т заасны дагуу байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарыг заавал ажиллуулж, цахим хуудсаар нээлттэй мэдээлэлтэй танилцах нөхцөлийг бүрэн хангах;

3.2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6- д заасан мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах арга хэмжээ авч ажиллах;

## **4 .Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, үр нөлөөг сайжруулах талаар:**

4.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн зөвлөмжийг хяналтад авч, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах;

4.2. Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт, суурь түвшин болон зорилтот түвшин, хүрсэн үр дүнг үндэслэн үнэн зөв, бодитой үнэлэх;

\*>

4.3. Төрийн албан хаагчдыг “Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, тайлагнал” сургалтад хамруулж чадавхжуулах;

**6.Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны талаар:**

5.1. Бүх багийн иргэдийн нийтийн хурлыг журамд заасан хугацааны дотор хуралдуулж, дараа онд хийх ажлын жагсаалтыг баталдаг байх;

5.2. Сумын Засаг даргын дэргэдэх ажлын хэсгийг 1 дүгээр улиралд багтаан холбогдох мэргэжлийн хүмүүсийг бүрэн оролцуулж байгуулах, захирамжийг удирдлагын мэдээллийн системд тухай бүр оруулж хэвших;

5.3. ОНХС-ийн хөрөнгөөр хийсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн эх үүсвэр, батлагдсан санхүүжилт зэрэг мэдээллийг 2 дугаар сард багтаан сумын албан ёсны цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлдэг байх;

5.4. Үнэлгээний хороог хууль, тогтоомжид заасан журмын дагуу байгуулж, ажиллуулах, мэдээллийг тухай бүр УМС болон бусад сувгаар нээлттэй үзэх боломжтой байрлуулах;

5.5. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн үр дүнг тухай бүр УМС-д оруулж, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгож байх;

5.6. Тухайн онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн үр дүнг, хэрэгжилтийн явцад ЗДТГ болон ИТХ-аас хяналт, шалгалт хийх, тайлан мэдээллийг УМС-д оруулах;

5.7. Өмнөх оны төвийн гүйцэтгэлээр бий болсон хөрөнгийн өмчлөл ашиглалтыг хүлээн авах комисс байгуулагдсан шийдвэр, хүлээн авсан акт, өмчлөлд бүртгэсэн, холбогдох этгээдэд хариуцуулсан нотлох баримтыг эргэж үзэх боломжтойгоор УМС-д байршуулах;

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст ирүүлэх;

032010000-

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭ  
ХЭЛТСИИН ДАРГА



Л.МАНДАЛ